



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2024.08.08 № 01/804  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН БАЯНЗҮРХ  
СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН  
ХОРООНЫ ДАРГА Г.ОДСЭР  
ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Ардчилсан намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

### Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

### Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

### Дүгнэлт

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Ардчилсан намын хорооны Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд

оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон холбогдох бусад хууль, тогтоомжид тус тус нийцсэн байна.

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Ардчилсан намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөр (5 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Ардчилсан намын хороонд

Хувийг: Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Сонгуулийн хороонд

Хавсралт . . . хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР



## **Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Ардчилсан намын хөтөлбөр**

**Үндсэн чиглэл:** 2024-2028 онд Баянзүрх сумын Ардчилсан намаас сум орон нутагт үйл ажиллагаа явуулдаг төсвийн байгууллагын бодлого хэрэгжилтийг дэмжиж, нийт иргэдийнхээ эрх ашгийг хангаж, Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа Алсын хараа-2050 хөтөлбөр, урт хугацааны хөгжлийн бодлого Монгол улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Хөгжсөн-Хөвсгөл 2030 хөтөлбөр, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх иргэдээс ирсэн ажлын санал нарыг тулгуурлан, мөрийн хөтөлбөрийг боловсруулахад чиглэсэн болно.

### **Нэг. Иргэдийн сэтгэл ханамж, эрх зүйн боловсролд суурилсан төрийн удирдлага**

1. Төрийн албан хаагчдын ажлын хариуцлагыг нэмэгдүүлж, ажлын чанар үр дүнг дээшлүүлнэ.
2. “ХОС БИЧИГТЭН-25” үндэсний хөтөлбөрийн хүрээнд аймгийн хэлний бодлогын зөвлөл, ЕБС-тай хамтран төрийн албан хаагчдын эх хэлний мэдлэгийг дээшлүүлэхэд анхаарч ажиллана.
3. 360 градусын үнэлгээний системийг нэвтрүүлнэ.
4. Бүх шатны төрийн байгууллагууд хөдөөгийн багт хүрч ажиллах “Төрийн үйлчилгээ-Малчны хотонд” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
5. Байгууллагын дэргэдэх “Эцэг, эхийн зөвлөл”-ийн үйл ажиллагааг идэвхжүүлэх
6. Хуулийн хөтөч- хөтөлбөр хэрэгжүүлнэ.
7. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, ажиллах нөхцөлийг сайжруулж, сургалтын материаллаг бааз, хэрэглэгдэхүүнийг нэмэгдүүлнэ.
8. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг нийтэд түгээж, авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх хандлага, ухамсрыг төлөвшүүлж, төрийн байгууллага, иргэдийн мэдээлэл солилцох тогтолцоог боловсронгуй болгон ил тод байдлыг хангана.
9. Сумын үйлдвэрчний эвлэлийг байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулна.
10. Аймгийн тэргүүний сум болно.
11. “Цахим Монгол” арга хэмжээг хэрэгжүүлнэ.
12. Сумын төр, төсвийн байгууллагын үйл ажиллагаанд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт, шалгалт, дотоод аудит хийх ажлыг жилд 1 удаа зохион байгуулах

### **Хоёр. Хүний хөгжлийн бодлого**




1. Залуучуудыг хөгжлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, залуучуудын хөгжлийн зөвлөл, залуучуудын элчийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, салбар зөвлөлийн төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг хангаж тайлагнах
2. Жендерийн боловсролыг бүх нийтэд олгох сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг өрнүүлэх
3. Цэцэрлэгийн болон бага насны хүүхдүүдэд Монголын түүх, хэл соёл, үндэсний өв, уламжлал ёс заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний үнэт зүйлээ дээдэлсэн иргэн болгох, сургах танин мэдүүлэх талаар боловсролын байгууллагын гаргасан санал санаачилгыг бодлогоор дэмжиж ажиллана.
4. "Оюунлаг Баянзүрх ирээдүй" дэд хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх
5. "Хамтарсан баг"-ийн үйл ажиллагааг сайжруулан хүүхдийн өмнө тулгамдаж буй асуудлыг оновчтой шийдвэрлэн залуучуудын холбоо, хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагуудыг бодлогын түвшинд дэмжиж ажиллана
6. "Хүүхдийн зөвлөл"-ийн дүрэм төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган хүүхдийн орчинд урьдчилан сэргийлэх хяналт тавих
7. Аймаг, орон нутгаас ахмадуудын дунд зохион байгуулж буй урлаг, спортын уралдаан, тэмцээнд ахмадуудын санал санаачилгыг дэмжиж ажиллана.
8. Гэр бүлийн хүчирхийллийн зөрчил, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулж, "Хүчирхийлэлгүй баг, сум" аяныг өрнүүлж үр дүнг тооцох
9. Суманд Монголын үг урлаачдын нийгэмлэгийн тэргүүн, олонд "ЧИЛАА" нэрээр танигдсан лектор Г.Бандицэрэн болон бусад үг урлаачдыг урьж хүүхэд, залуус, насанд хүрэгчдэд лекц авах, оюуны соён гэгээрлийн ажлыг жилд нэг удаа хийнэ.

#### **Гурав. Эрүүл мэндийн зорилт**

1. Иргэн бүрийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг, оношилгоо, халдварт, халдварт бус өвчний эрт илрүүлгийн цогц үйлчилгээ шинжилгээнд бүрэн хамруулах
2. Эрүүл мэндийн төвийн нийт үзлэгт гэрийн эргэлтийн эзлэх хувийг нэмэгдүүлж, жирэмсний эхний 3 сарын хяналтыг сайжруулж, эх, нялхсын эндэгдэлгүй ажиллана
3. Эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох олон талт нөлөөллийн ажлыг зохион байгуулах
4. "Эрүүл хүүхэд бидний ирээдүй" урианы дор хүүхэд бүрийг жил болгон эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт, шаардлагатай тохиолдолд шинжилгээнд хамруулан, эрүүл өсөж бойжих нөхцөлийг бүрдүүлнэ

#### **Дөрөв. Боловсролын бодлого**

1. Бага, дунд боловсролын чанарын болон суралцагчийн сургалтын ахиц, дэвшлийн үнэлгээг тогтмол хийж, хоцрогдлыг арилгах цогц төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах





2. Мал эмнэлэг үржлийн тасаг, мал эмнэлгүүдийн ажлын уялдаа холбоог сайжруулж, төрөөс тавих хяналтыг нэмэгдүүлэх замаар урьдчилан сэргийлэх арга хэмжээг чанаржуулж, малчдыг мэдээллээр бүрэн хангаж “Эрүүл малтай сум” болно.
3. Малын тоо толгойн албан татварыг сумын ИТХ-аар хэлэлцүүлэн тогтоож хэрэгжилтийг ханган ажиллана, Татвар төлөгчдийг татварын хуулийг сайн дураараа дагаж мөрдөх дадалд хэвшүүлэх тэдний татварын боловсролыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулна
4. “Тэрбум мод тарих хөдөлгөөн”-ийг эрчимжүүлж ногоон байгууламж ойжуулалтын хэмжээг нэмэгдүүлэх
5. Ойн санг нөхөн сэргээж ойжуулах хөдөлгөөн өрнүүлэн ард иргэдийн оролцоотойгоор ой цэвэрлэгээний ажлуудыг зохион байгуулна.
6. Хортон устгалын ажлыг зохион байгуулах
7. Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх,хамгаалах, сургалт сурталчилгааг зохион байгуулах
8. “Хоршооны хөгжлийг дэмжих жил”-ийн хүрээнд хоршоодын үйл ажиллагааг дэмжих ажлыг зохион байгуулах

#### **Найм. Ил тод төсөв, санхүүгийн бодлого**

1. Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэлийн үнэлгээний хувийг 50%-д хүргэж, сум хөгжүүлэх сангийн хөрөнгө болон суманд ирж буй аливаа төсөл, хөтөлбөрүүдийг иргэдэд нээлттэй мэдээлнэ..
2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулж шуурхай удирдлагаар ханган ажиллах, төсөвт байгууллагын шилэн дансны мэдээллийн үнэн зөв, бодит байдалд хяналт тавин ажиллах
3. ХАА ажиллагааг журмын дагуу зохион байгуулж, тайланг хуулийн хугацаанд тайлагнаж хэвших

#### **Ес. Иргэдийн хүсэл сонирхолд тулгуурласан хөрөнгө оруулалтын зорилтууд**

1. Сумын төвд гэрэлтүүлгийг тогтмол нэмэгдүүлэх
2. Орон нутаг судлах музейтэй болох асуудлыг холбогдох байгууллагуудад хүсэлт тавьж шийдвэрлүүлэх арга хэмжээ авах
3. Эмт,Хайс, багийн перевоз буулгах, хураах ажлыг жил бүр хийх
4. Хайс Агар Тоом багийн цахилгааны хүчин чадлыг нэмэгдүүлэх талаар аймгийн ИТХ-д уламжилж шийдвэрлүүлэх арга хэмжээ авах
5. Шаардлагатай цэгүүдэд мал угаалгын ванн барих
6. Бэлчээрийн усан хангамжийг тогтмол нэмэгдүүлэх Эмт багт Холбогдох байгууллагад хүсэлт тавих, шийдвэрлүүлэх
7. Шаардлагатай зам даваагаа өөрсдөө засдаг индүү авто грейдр, HOWO машинтай орон нутгийн өмчит компани байгуулах талаар дээд шатны ~~байгууллагад~~ уламжлах, шийдвэрлүүлэх



8. Улаанбаатар хотод Баянзүрх сумын малчдын махыг худалдаалдаг хөргүүр бүхий цэг байгуулах талаар судалж холбогдох эрх бүхий байгууллагад хүсэлт тавьж шийдвэрлүүлэх
  9. Баянзүрх сум сумын төвийг бетон хучилттай авто замтай болгох асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хүсэлт тавьж шийдвэрлүүлэх
  10. 440 хүүхдийн хичээлийн байрны барилгын ажлыг үргэлжлүүлэх, хяналт тавих
  11. 220 хүүхдийн дотуур байраа ашиглалтад оруулах, хүлээж авах
  12. Соёл спортын цогцолборын барилгын ажлыг үргэлжлүүлэх ашиглалтад оруулах
  13. Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн ажлыг УИХ-д өргөн мэдүүлж шийдвэрлүүлэх
  14. Эрүүл мэндийн төвийн бүрэн тоногдсон түргэн тусламжийн шинэ авто машиныг эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлэх
  15. Бэлтэс 5-р багийн бетонон гүүр барих ажлыг УИХ-д өргөн мэдүүлж шийдвэрлүүлэх арга хэмжээ авна
  16. Малын хулгайтай тэмцэх, нөхөрлөл, хоршоололтой хамтран ажиллах
  17. Олон нийтийн оролцоотой хөрөнгө оруулалтын бодлогуудыг хэрэгжүүлэх
  18. Нийтийн биеийн тамирын талбайгаа соёл, амралтын талбар болгох ажлыг эхлүүлэх
  19. Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах
- Нэг. Иргэдийн сэтгэл ханамж, эрх зүйн боловсролд суурилсан төрийн удирдлага-12*
- Хоёр. Хүний хөгжлийн бодлого - 9*
- Гурав. Эрүүл мэндийн чиглэлээр-4*
- Дөрөв. Боловсролын үйлчилгээний чиглэлээр—6*
- Тав. Биеийн тамир, спорт, соёл урлагийн үйлчилгээний чиглэлээр-7*
- Зургаа. Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж, нийгмийн даатгалын чиглэлээр-4*
- Долоо. Хөдөө аж ахуй ногоон хөгжлийн бодлого-8*
- Найм. Ил тод төсөв санхүүгийн чиглэлээр-3*
- Ес. Иргэдийн хүсэл сонирхолд нийцсэн хөрөнгө оруулалтын бодлогууд 19*
- Нийт 72 зорилтыг хэрэгжүүлэхээр төлөвлөв.*

### Баянзүрх сумын Ардчилсан нам

